



ОРХОНТУУЛ СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2020 07 30 № 107-2020/04-НА-10
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхонтуул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Орхонтуул сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орхонтуул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Орхонтуул сумын Монгол Ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020575


Дүгнэлт

Орхонтуул сумын Монгол Ардын намын хорооны Орхонтуул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Орхонтуул сумын Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /...7... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Орхонтуул сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**

**СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Орхонтуул сум
2020 он

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



“ХҮЧЭЭ НЭГТГЭЖ-ЭХ НУТГАА ХӨГЖҮҮЛЬ”

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙ-НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. МАЛ АЖ АХУЙН БОДЛОГО

- 1.1.1. Сумын төв Рашаант тосгоны төвүүдэд баригдсан сүү хөргүүрийн цехүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулж, мэргэжлийн боловсон хүчнээр хангаж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.1.2. Хөдөөгийн хүн ам, мал аж ахуйн усан хангамжийг сайжруулах замаар бэлчээрт худаг, уст цэгийн тоог нэмэгдүүлж алслагдсан бэлчээрийг бүрэн ашиглана.
- 1.1.3. Малын үүлдэр угсааг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлж өндөр ашиг шимт үүлдрийн үржлийн аж ахуй эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжиж ажиллана.
- 1.1.4. Малын гаралтай сүү сүүн бүтээгдэхүүн цагаан идээгээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч иргэдийг дэмжиж зах зээлд нийлүүлэх боломжийг хангахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.1.5. Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах цех жижиг үйлдвэрүүдийг бий болгож буй иргэн аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.1.6. Сумын хэмжээнд явуулын мал угаалгын ванны үйл ажиллагааг тогтмолжуулна.
- 1.1.7. Мал эмнэлэг үржлийн тасаг, мал эмнэлгүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулж, төрөөс тавих хяналтыг нэмэгдүүлэх замаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанаржуулж, малчдыг мэдээллээр бүрэн хангаж ажиллана.
- 1.1.8. Залгамж халаа болж буй Залуу малчин, тариаланчдыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.1.9. Хагас болон бүтэн эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.

1.2. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН БОДЛОГО

- 1.2.1. Эрчим хүчний шугам татах боломжтой төмс хүнсний ногооны талбайн орчим шинэ суурьшлын бүс бий болгож цахилгааны шугам тавих ажлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлнэ.
- 1.2.2. Газар тариалан төмс хүнсний ногоо, жимс жимсгэнийн аж ахуй эрхлэгч иргэн аж ахуйн нэгж байгууллагыг техник технологио шинэчлэх, хүлэмжийн аж ахуйн төсөл хөтөлбөрт хамрагдахад нь дэмжлэг үзүүлнэ.
- 1.2.3. Төмс хүнсний ногоо эрхлэгчдэд дундаа ашиглах агуулах зоорьтой болгож хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх замаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн борлуулалтын нэгдсэн сүлжээ бий болгоход анхаарч ажиллана.



- 1.2.4. Төмс хүнсний ногоогоор нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулалтын нэгдсэн сүлжээ бий болгох асуудлыг бодлогоор дэмжинэ.
- 1.2.5. Сумын нийт үр тарианы талбайг хашаажуулах ажлыг тариалан эрхлэгч аж ахуйн нэгж иргэдээр бүрэн хийлгэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.


1.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

- 1.3.1. Уул уурхайн зориулалтаар ашиглагдаж эвдрэлд орсон газруудыг тусгай зөвшөөрөл эзэмшигчдээр зохих хууль журмын дагуу нөхөн сэргээлгэж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.
- 1.3.2. Рашаан булгийн эхүүдийг хашаажуулж иргэд малчдын оролцоотойгоор хамгаалалтыг сайжруулна.
- 1.3.3. Ойн санг нөхөн сэргээж ойжуулах хөдөлгөөн өрнүүлэн ард иргэдийн оролцоотойгоор ой цэвэрлэгээний ажлуудыг зохион байгуулна.
- 1.3.4. Тариалангийн талбайн хэмжилтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, талбай тэлсэн аж ахуйн нэгж, байгууллагад хууль журмын дагуу хариуцлага тооцно.
- 1.3.5. Уул уурхай, газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа тогтмол явуулдаг аж ахуйн нэгж, компанитай сум, орон нутгийг хөгжүүлэх тал дээр хамтарч ажиллана.
- 1.3.6. Сумын төвүүдийн хогийн цэгүүдийг шаардлага хангасан зохион байгуулалттай болгож, хог ангилан ялгах технологийг нэвтрүүлнэ.
- 1.3.7. Хадлан, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх талаар санал санаачилга гаргасан иргэн, аж ахуйн нэгжийг бүх талаар дэмжиж ажиллана.
- 1.3.8. Хоёрдогч түүхий эд болон хуванцар, хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах иргэн, аж ахуйн нэгжийн санал санаачилгыг дэмжинэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. НИЙГМИЙН БОДЛОГО

2.1. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДАД ЧИГЛЭСЭН БОДЛОГО

- 2.1.1. Гэр цэцэрлэгийн үйл ажиллагааг дэмжиж чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.1.2. Цэцэрлэгийн болон бага насны хүүхдүүдэд Монголын түүх, хэл соёл, үндэсний өв, уламжлалт ёс заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний үнэт зүйлээ дээдэлсэн иргэн болгох, сургах танин мэдүүлэх талаар боловсролын байгууллагын гаргасан санал санаачилгыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.1.3. Сумын сургуулийн номын сангийн нөөцийг үндэсний болон дэлхийн сонгодог уран зохиолын номуудаар баяжуулан номын худалдааны сүлжээтэй болно.
- 2.1.4. “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг өргөжүүлж, чанар хүртээмжийг дээшлүүлэх замаар шинэ залуу боловсон хүчнийг сум, орон нутагтаа ажиллах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.1.5. “Эрүүл хүүхэд бидний ирээдүй” уриан дор хүүхэд бүрийг жил болгон эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт, шаардлагатай тохиолдолд шинжилгээнд хамруулан, эрүүл өсөж бойжих нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.1.6. Шинэ залуу боловсон хүчнийг сумандаа ирж ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх талаар бүхий л арга хэмжээг авч ажиллана.
- 2.1.7. Спорт цогцолбор барьж хүүхэд залуусыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжоор хангана.

- 
- 2.1.8. Үндэсний болон аймаг сумын дэд хөтөлбөрүүдэд үнэлэлт дүгнэлт гарган цаашид хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг шинээр боловсруулж хэрэгжүүлнэ.
 - 2.1.9. Их дээд сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгссөн залуучууд, гадаад улсад сурч, ажиллаж байгаад ирсэн залуучуудын мэдлэг, туршлагыг бусадтай хуваалцах, нутагшуулах зорилгоор байнгын эргэх холбоотой байж орон нутгийн хөгжлийнхөө төлөө хамтран ажиллана.
 - 2.1.10. Залуучуудын холбоо, хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагуудыг бодлогын түвшинд дэмжиж ажиллана.
 - 2.1.11. Монгол Улсын засгийн газрын болон, гадаад дотоодын их дээд сургуулиуд, амжилттай хэрэгжиж буй төрийн бус байгууллагуудын тэтгэлэгт оюутан залуучуудыг хамруулах талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.
 - 2.1.12. Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, нийгмийн төлөвшилтийг дэмжихэд эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.
 - 2.1.13. Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг сайжруулна.

2.2. ДУНД НАСНЫХАНД ЧИГЛЭСЭН БОДЛОГО

- 2.2.1. Сумын баялаг бүтээгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг сумын иргэд, төр, төсвийн байгууллагыг хангах талаар бодлого барьж ажиллана.
- 2.2.2. Иргэн бүрийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгт хамруулах, хөдөөгийн айл өрхүүдэд явуулын тусламж үйлчилгээг үзүүлж, хүн амын эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлнэ.
- 2.2.3. Дунд насны иргэдийг халдварт, халдварт бус өвчний эрт илрүүлгийн цогц үйлчилгээ оношилгоог эрүүл мэндийн газартай хамтран жил бүр зохион байгуулна.
- 2.2.4. Хүн бүр угийн бичгээ хөтлөх талаар соёлын байгууллагатай хамтран мэдээллийн шинэ орчныг бий болгоно.
- 2.2.5. Өрх толгойлсон эцэг, эх хөгжлийн бэрхшээлтэй иргэний жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар гаргаж буй санал санаачилгыг дэмжинэ.

2.3. АХМАД НАСТАНД ЧИГЛЭСЭН БОДЛОГО


- 2.3.1. Сумын хэмжээнд мод, бут, сөөг үржүүлэх, цэцэрлэгжүүлэхэд ахмадуудтай хамтран ажиллах, ногоон орчныг хамгаалах зэрэг нийтэд тустай ажил үйлчилгээ эрхлэх санал санаачилгыг дэмжиж хамтран ажиллана.
- 2.3.2. Жил бүр ахмадуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах арга хэмжээ авна.
- 2.3.3. Ахмадуудын амьдрал, ажлын туршлагыг хүүхэд, залуучууд, төр төсвийн байгууллагуудын ажилтан албан хаагч нарт өвлүүлэх зорилго бүхий “Өвлүүлэн сургах” арга хэмжээг жил бүр зохион байгуулдаг болно.
- 2.3.4. Улс, аймаг, орон нутгаас ахмадуудын дунд зохион байгуулж буй урлаг, спортын уралдаан, тэмцээнд ахмадуудын санал санаачилгыг хөхүүлэн дэмжиж ажиллана.
- 2.3.5. Ахмадын холбоо болон төрийн бус байгууллагуудыг бодлогын бүхий л түвшинд дэмжиж ажиллана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСАГ ДЭД БҮТЦИЙН БОДЛОГО

3.1. ДЭД БҮТЦИЙН БОДЛОГО

- 3.1.1. Сумын төвийн цэцэрлэгийн барилгын их засвар, гадна тохижилтын ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж, холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 3.1.2. Сумын төвийн Эрүүл мэндийн төвийн барилга, туслах барилгын их засварын ажлын төсөв, тооцоог гарган, шийдвэрлүүлэх талаар холбогдох байгууллагад уламжилж, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.1.3. Рашаант тосгоны эрүүл мэндийн төвд туслах барилга шинээр барих тооцоо судалгаа, зураг төсвийг хийлгэж, ашиглалтад оруулах талаар холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлж ажиллана.
- 3.1.4. Сумын төвийн цэвэрлэх байгууламжийг шинээр барих зураг төсөв, тооцоо судалгааг хийж, холбогдох байгууллагуудад санал хүргүүлэн шийдвэрлүүлнэ.
- 3.1.5. Сумын төвийн дулааны төв шугам сүлжээг шинэчлэх ажлыг холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх тал дээр анхаарч ажиллана.
- 3.1.6. Рашаант тосгонд 50 хүүхдийн хүчин чадал бүхий дотуур байрыг шинээр барих, ашиглалтад оруулах ажлыг холбогдох байгууллагуудад уламжилж, шийдвэрлүүлэх тал дээр анхаарч ажиллана.
- 3.1.7. Сумыг 1-р сургуулийн дотуур байрыг их засварт оруулах ажлын зураг төсвийг хийлгэж, холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлнэ.
- 3.1.8. Монгол Улсын Засгийн газрын Бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсанаар Төв аймгийн Цээл сумаас Орхонтуул сумын нутгаар дайран Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумтай холбох босоо тэнхлэгийн засмал замын ажлын зураг төсөв, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн дээд шатны байгууллагуудаар шийдвэрлүүлнэ.
- 3.1.9. Орхон голын төмөр бетон гүүр барих ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, бүх талаар дэмжиж ажиллана.
- 3.1.10. Гэр хорооллын айл өрхийг бүлгийн зохион байгуулалтад оруулж хашааг шинэчлэх хөдөлгөөн өрнүүлэх замаар гэр хорооллын өнгө үзэмжийг сайжруулан, иргэдийн гаргасан санал санаачилгыг дэмжин хаягжуулалтын шинэ системийг нэвтрүүлнэ.
- 3.1.11. Сумын төв болон Рашаант тосгоны гэрэлтүүлэг, камерын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 3.1.12. Сумын төв болон Рашаант тосгоны орон сууцны хорооллуудын барилгын дээврийн засвар, гадна фасадын засварын ажлыг холбогдох байгууллагуудад санал тавьж шийдвэрлүүлнэ.
- 3.1.13. Сумын төвийн соёлын төвийн барилгын их засварын ажлыг дээд шатны байгууллагуудад уламжилж, шийдвэрлүүлэх тал дээр анхаарч ажиллана.
- 3.1.14. Сумын төвийн усан сангийн их засварын ажлыг хийж гүйцэтгэх талаар холбогдох байгууллагуудад уламжилж, найдвартай ажиллагааг хангах тал дээр анхаарч ажиллана.

- 3.1.15. Сумын төвийн 1 км төв замыг дотоодын нөөц бололцоог ашиглан, иргэн, аж ахуйн нэгжүүдийг түшиглэж, бетон цутгамал зам болгох талаар хамтарч ажиллана.
- 3.1.16. Сумын түүхт 90 жилийн ойг угтан бүтээлч ажлуудыг санаачлан хандивын аян өрнүүлж, баяр наадмын талбайг шинээр барьж байгуулна.




3.2. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 3.2.1. Чулуутын бригад, Салхитын бригад, 97 дугаар зөрлөгт үүрэн холбооны дахин дамжуулах станц байгуулах ажлыг холбогдох үүрэн холбооны операторуудад санал тавьж шийдвэрлүүлнэ.
- 3.2.2. Рашаант тосгоны соёлын төвийг шинэ техник, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана.
- 3.2.3. Рашаант тосгоны 75 хүүхдийн цэцэрлэгийг шинэ техник, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана.
- 3.2.4. Шатахуун түгээх станцуудын төрлийг /автын болон ахуйн газ/ нэмэгдүүлж, шударга өрсөлдөөн бий болгох замаар ажлын байр нэмэгдүүлэх иргэн, аж ахуйн нэгжийн санал санаачилгыг дэмжинэ.
- 3.2.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар түр болон байнгын ажлын байр нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийн шинэ тогтвортой бодлогыг хэрэгжүүлж ажиллана.
- 3.2.6. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тулгуурлан Орхонтуул сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж, "Орхонтуул алсын хараа-2040" бодлогын баримт бичгийг батлуулж, мөрдөж ажиллана.
- 3.2.7. Худалдаа, үйлчилгээний салбарын үйлчилгээний чанар, боловсон хүчний чадавхыг сайжруулж, үйлчилгээний соёл, стандарт, эрх үүргийн тухай мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, мэдээллийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 3.2.8. Төсвийн төлөвлөлт зарцуулалт, орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтыг оновчтой болгон төсвийн сахилга бат, шилэн дансны хяналт, ил тод байдлыг эрхэмлэнэ.
- 3.2.9. Төмс, хүнсний ногоо угааж савлах, боловсруулалт хийх үйлдвэрийг байгуулах иргэн, аж ахуйн нэгжийн санал санаачилгыг дэмжинэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ЧИГЛЭСЭН БОДЛОГО

- 4.1.1. Бодлого, төлөвлөлт, боловсруулалт, хэрэгжүүлэлтийн үе шат бүрд иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлж, үр дүнд суурилсан хяналт – шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлнэ.
- 4.1.2. Төр, төсвийн байгууллагуудад "Соёлтой харилцаа-Шуурхай үйлчилгээ" хөдөлгөөнийг өрнүүлж, иргэнээ дээдэлсэн төрийн үйлчилгээг төлөвшүүлж, Бүтээлч, Бүтээгч хариуцлагатай засаглалыг бий болгоход анхаарч ажиллана.
- 4.1.3. Төсвийн хөрөнгө оруулалт, худалдан авалт, тендерийн сонгон шалгаруулалт болон гүйцэтгэлийн шатанд иргэдийн оролцоотой хяналт тавьж, шударгаар дүгнэж иргэдэд тайлагнадаг болно.



- 
- 4.1.4. Сумын ИТХ, Засаг Даргын Тамгын газар, Рашаант тосгоны үйл ажиллагааг олон нийтэд ил, тод болгох, гаргаж буй эрх зүйн акт, баримт бичгүүдийг цахим хэлбэрээр нээлттэй байршуулна.
 - 4.1.5. Сумын төр, төсвийн байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлт, албан хаагчдын сонгон шалгаруулалтыг нээлттэй ил тодоор сонгон шалгаруулах тал дээр хяналт тавьж ажиллана.
 - 4.1.6. Төр, төсвийн байгууллагуудын ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг сайжруулах, туршлага эзэмшүүлэх зорилгоор сургалтад тогтмол хамруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
 - 4.1.7. Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.
 - 4.1.8. Төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, хандлагыг эрс шинэчилнэ.


4.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГО

- 4.2.1. Эмнэлгийн яаралтай тусламж болон сэргээн засах эмчилгээний тоног төхөөрөмж, анализатор, лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчилж, мэргэжлийн боловсон хүчнээр хангах бодлого хэрэгжүүлнэ.
- 4.2.2. Эмнэлгийн эмч сувилагч нарыг богино болон урт хугацааны сургаалтанд хамруулж мэдлэг боловсролоо дээшлүүлэх талаар хамтарч ажиллана.
- 4.2.3. Иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулахаар сум орон нутгаас гаралтай мэргэжлийн эмч нарын багийн гаргасан санал санаачилгыг дэмжиж ажиллана.

4.3. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОДЛОГО

- 4.3.1. Цагдаагийн болон ар гэрийн ажиллах нөхцөл бололцоог дээшлүүлэх талаар бүхий л түвшинд дэмжлэг үзүүлнэ.
- 4.3.2. Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор сум орон нутгийн хэсгийг тээврийн хэрэгслээр хангаж, ажил үүрэг гүйцэтгэх нөхцөл бололцоог сайжруулна.
- 4.3.3. Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор малчид иргэдтэй хамтран морьт эргүүл ажиллуулж, холбоо мэдээллээр хангах ажлыг шуурхай болгоно.

4.4. БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН БОДЛОГО

- 4.4.1. ЕБС, цэцэрлэгийн багш, ажилтны тасралтгүй хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх, гадаад дотоодын сургалт, үйл ажиллагаанд хамруулж, мэргэжилтэй боловсон хүчний мэдлэг боловсролыг дээшлүүлж, шатлан дэвшиж ажиллах нөхцөлийг бүрдүүлэх тал дээр анхаарч ажиллана.
 - 4.4.2. Боловсролын салбарыг улс төрөөс ангид байлгаж, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг мэдлэг чадвар, ажлын гүйцэтгэл, туршлагад нь үндэслэн сонгон шалгаруулж томилно.
 - 4.4.3. ЕБС-ын сургуулиудын үдийн цай, хоол, цэцэрлэгийн хүүхдүүдийн цай хоолны үйлчилгээг сайжруулж хүүхдэд шим тэжээл, амин дэмээр баялаг хоолоор үйлчилнэ.
- 

- 4.4.4. Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй хүүхэд сургууль цэцэрлэгт сурах, хөгжих орчин бүрдүүлэх тал дээр анхаарч ажиллана.
- 4.4.5. Суралцагчдад сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, мэргэжлээ сонгоход туслах чиг үүрэгтэй нийгмийн ажилтнуудыг ажлаа мэргэжлийн түвшинд гүйцэтгэх боломжийг хангуулна.
- 4.4.6. Хичээлээс гадуурх сургалтын үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж хүүхдийн хүсэл сонирхол, ой тогтоолт, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- 4.4.7. Улс, олон улсын түвшинд зохион байгуулагдаж буй олимпиад, уралдаан тэмцээнд оролцож, амжилт үзүүлсэн суралцагч, багш, багийг дэмжин ажиллана.
- 4.4.8. Үндэсний болон спортын төрөл бүрийн холбоо, төрийн бус байгууллагуудыг бодлогын түвшинд дэмжиж хамтран ажиллана.

ОРХОНТУУЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО